

**БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ХУБЭЙ МУЖИЙН УХАНЬ
ХОТНОО ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН “НИСЛЭГИЙН ЦАГ УУР”
СЭДВИЙН ХҮРЭЭНД “НИСЛЭГТ АЮУЛТАЙ ЦАГ АГААРЫН ҮЗЭГДЭЛ
АЯНГА ЦАХИЛГААН ИЛРҮҮЛЭХ СҮЛЖЭЭНИЙ ТЕХНОЛОГИ,
МЭДЭЭЛЛИЙН АШИГЛАЛТ” ОЛОН УЛСЫН СУРГАЛТАД
ХАМРАГДСАН ТУХАЙ ТАЙЛАН**

2024 оны 11дүгээр сарын 08-ны өдөр

Улаанбаатар хот

1. Сургалтын зорилго:

БНХАУ-ын Шинжлэх Ухааны Академи, Нислэгийн хөдөлгөөний удирдлагын товчоо, СААС (АТМВ) санхүүжилтээр зохион байгуулагдсан “Нислэгт аюултай цаг агаарын үзэгдэл аянга цахилгаан илрүүлэх сүлжээний технологи, мэдээллийн ашиглалт” сэдэвт олон улсын сургалтад хамрагдаж, нислэгт аюултай цаг агаарын үзэгдэл аянга цахилгааныг урьдчилан мэдээлэх арга аргачлал, аянга цахилгаан илрүүлэх систем, хиймэл дагуулын болон цаг уурын радарын мэдээ, мэдээллийг ашиглан нислэгт аюултай цаг агаарын үзэгдлээс урьдчилан сэргийлэх, цаг агаарын аюултай үзэгдэл элементийн төлөв байдлыг үнэлэх зэрэг шинжлэх ухаан технологийн ололтыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, хэрэгжүүлэх арга замыг судалж сурах зорилготой.

2. Сургалтад хамрагдсан ажилтан:

Нислэгийн цаг уурын төвийн мэдээлэл үйлчилгээний хэлтсийн ерөнхий инженер Б.Сүхбаатар.

3. Сургалт зохион байгуулагдсан газар:

БНХАУ-ын Хубэй мужийн Ухань хотод байрлах Шинжлэх ухааны академи, инженер электроникийн институтийн сургалтын төвд зохион байгуулагдсан.

4. Сургалтын хугацаа:

2024 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 02-ны өдрүүдэд.

5. Сургалтын талаар:

БНХАУ-ын Шинжлэх Ухааны Академи, Нислэгийн хөдөлгөөний удирдлагын товчоо, СААС (АТМВ) санхүүжилтээр зохион байгуулагдсан “Нислэгт аюултай цаг агаарын үзэгдэл аянга илрүүлэх сүлжээний технологи, дата хэрэглээ” сэдэвт олон улсын сургалтад амжилттай хамрагдлаа. Энэхүү сургалтыг БНХАУ-ын Шинжлэх Ухааны Академийн Цахилгаан инженерингийн хүрээлэн, Нисэхийн цаг уурын төв (АТМВ), Хубэй мужийн цаг уурын төвийн сургагч багш нар удирдан явуулсан. Сургалтад ашиглагдсан бүх материал, мэдээ мэдээллийг электрон хэлбэрээр авчирсан.

Тус сургалтад 7 орны нийт 18 оролцогчид тус сургалтад хамрагдсан. Үүнд: Пакистан улсаас-3, Монгол улсаас -2, Казакстан улсаас-1, Киргизстан улсаас-1, Лаос улсаас-4, Мальдив улсаас-4, Камбож улсаас-3 оролцогч тус тус оролцсон.



Сургалтын хугацаанд дараах сэдвүүдийг судаллаа. Үүнд:

- БНХАУ-ын нисэхийн цаг уурын үйлчилгээний талаар;
- Нисэхийн цаг уурын үйлчилгээнд аянга цахилгааныг илрүүлэх системийг хэрхэн ашиглах, бүтээгдэхүүнийг нислэгт ашиглах талаар;
- Нислэгт аюултай цаг агаарын үзэгдэл болох аянгын ажиглалт, тэдгээрийг урьдчилан мэдээлж нислэгийн аюулгүй ажиллагааг хангах талаар;
- БНХАУ-ын Хубэй мужийн цаг уурын байгууллагатай танилцаж тус мужийн нисэхийн цаг уурын төв, нислэгийн цаг уурын үйлчилгээ, аянга цахилгааны гамшгийг хянах, хамгаалах систем, сэрэмжлүүлэх мэдээг гаргаж буй үйл ажиллагааны талаар;
- Аянга цахилгааны гамшгийн тохиолдлууд болон мэдээний боловсруулалт;
- Аянга илрүүлэх системийн технологи, өгөгдөл боловсруулах аргачлал, засвар үйлчилгээний талаар.

Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр сүүлийн жилүүдэд ихэнх бүс нутаг ялангуяа Ази тивд байгалийн гамшгийн тоо давтагдал олширч учруулж буй хор хөнөөл нь жилээс жилд нэмэгдсээр байгаа юм байна.

Аянга цахилгаан эрт илрүүлэх нь цаг агаарын төлөв байдалд хяналт шинжилгээ хийх, нислэгийг цаг агаарын аюултай үзэгдлийн бодит болон урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллээр шуурхай хангах, цаг агаарын аюултай үзэгдэл, аянга цахилгаанаас шалтгаалсан байгалийн болзошгүй гамшгийн эрсдэлээс хүний амь нас, эд хөрөнгө, хүрээлэн буй орчныг хамгаалах, нисэхийн аюулгүй ажиллагаа, эдийн засагт бодитой хувь нэмэр оруулахад чухал ач холбогдолтой юм.

Сургалтад оролцогчид өөрийн орны нисэхийн цаг уурын үйлчилгээ болон нислэгт аюултай цаг агаарын үзэгдэл болох аянгыг урьдчилан мэдээлж байгаа байдал болон ашиглаж буй системийн талаар танилцуулж тэдгээрийн давуу болон сул талууд цаашид нисэхийн цаг уурын үйлчилгээг сайжруулахад хийгдэх шаардлагатай ажлуудын талаар хэлэлцүүлэг хийсэн. БНХАУ нь өөрийн орондоо 530 (short range-500, long range-30) аянга цахилгаан илрүүлэх системийг

суурилуулж мэдээллийг нь нисэх болон цаг уур, ойн газар, цахилгаан эрчим хүч, онцгой байдал зэрэг байгууллагууд үйл ажиллагаандаа ашиглаж байгаа юм байна.

Дэлхий нийтээр байгалийн гамшиг хөнөөл нэмэгдэж түүний дотор хөгжиж байгаа болон буурай хөгжилтэй орнууд ихээхэн нэрвэгдэж байгаа тул БНХАУ-ын “Нэг бүс, нэг зам” санаачилгын хүрээнд дараах улс орнуудад БНХАУ-ын Засгийн газрын санхүүжилтээр аянга цахилгаан илрүүлэх системийг суурилуулсан байна. Үүнд: Пакистан улс-28(short range-26, long range-2), Лаос улс-7(long range-7), Мальдив улс-6(short range-6, long range-1), Камбож улс -15(short range-12, long range-3), Шри-ланка-10(short range-9, long range-1), Бангладеш-10(short range-9, long range-1) аянга цахилгаан илрүүлэх систем байдаг юм байна. Сүүлийн жилүүдэд цаг агаарын гамшигт үзэгдлийн тоо өсөж байгаа нь цаг агаарын мэдээний чанар таарцад ихээхэн нөлөө үзүүлж байгааг онцолсон.

6. Гарсан үр дүн:

Манай орны хувьд дулааны улиралтай холбоотойгоор үүсдэг нислэгт аюултай цаг агаарын үзэгдлүүд ялангуяа конвекцийн гаралтай аянга цахилгааныг урьдчилан мэдээлэхэд шаардлагатай зарим цаг уурын параметруудийг тооцоолох асуудлын талаар бусад улс орнуудаас туршлага судалж солилцон мэдлэг мэдээллээ ахиулсан үр дүнтэй сургалт болсон.

Сургалт зохион байгуулж буй орон БНХАУ нь аянга цахилгааныг хэрхэн илрүүлэх ажиглах, мэдээлэх талаар 30 жилийн турш судалгаа шинжилгээний ажил хийсэн байна. Нэг бүс, нэг зам санаачилгын хүрээнд хөгжиж орнуудад нислэгт аюултай цаг агаарын үзэгдэл аянгыг ажиглах, урьдчилан мэдээлэх үйл ажиллагааг сайжруулах зорилгоор БНХАУ-ын Засгийн газрын санхүүжилтээр бусад улсуудад төсөл хэрэгжүүлэх боломжтой байгааг онцолсон. Буянт-Ухаа олон улсын нисэх буудал орчимд жилд дунджаар 30-37 удаа аянга цахилгаан ажиглагдаж байгаа ба аянга цахилгааны улмаас нисэхийн цахилгаан холбооны тоног төхөөрөмжүүд гэмтэж нислэгийн үйл ажиллагаанд нөлөөлдөг тул тус төслийг манай улсад хэрэгжүүлэх боломжтой эсэх талаар ярилцаж сургалт зохион байгуулж буй болон төсөл хэрэгжүүлж буй байгууллагад хүсэлт тавьсан. Энэхүү хүсэлтийг хүлээн авч төслийг хэрэгжүүлэх зөвшилцөлд хүрч Хамтын ажиллагааны санамж бичгийн төслийг өгсөн.

Тус төслийг хэрэгжүүлснээр аянга цахилгааны улмаас гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлж нисэхийн аюулгүй ажиллагааг хангаж цахилгаан эрчим хүч, тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангах байгалийн гамшгийн аюулыг бууруулах боломж бүрдэнэ.

Сургалтын хугацаанд өөрийн орны нислэгийн цаг уурын үйл ажиллагаа, нислэгт аюултай цаг агаарын үзэгдлийн талаар илтгэл тавьж хэлэлцүүлсэн. Сургалтын төгсгөлд улс энэхүү төслийн хүрээнд цаашид зохион байгуулагдах сургалтуудад Нисэхийн цаг уурын төвөөс инженер техникийн ажилтнуудыг хамруулах, ашиглаж буй нислэгт аюултай цаг уурын үзэгдэл элементийг урьдчилан мэдээлэх программыг ашиглан ажлын байран дээр сургалт дадлага хийлгэх боломжийг ярилцсан. Нисэхийн аюулгүй ажиллагааг хангаж ажиллахад чухал хувь нэмэр оруулах, цаг уурын үйл ажиллагааг сайжруулахад юуг анхаарах ёстойг заасан үр өгөөжтэй сургалт боллоо.

Бусад улс орнуудад аянга цахилгаан илрүүлэх системийг нисэхийн болон бусад салбарын үйл ажиллагаанд ашиглаж нийгэм эдийн чухал ач холбогдолтой байгаатай танилцаж Монгол улсын хувьд дээрх төсөл хөтөлбөрт хамрагдсанаар

аянга цахилгааныг эрт сэрэмжлүүлэх нөхцөл бүрдэх боломжтой байгаа нь байгалийн гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж нисэхийн үйл ажиллагаанд ашиглах боломжийг бүрдүүлэх ба бусад улс орнуудаас туршлага судлан цаашдын үйл ажиллагааг сайжруулахад маш том түлхэц өгсөн ач холбогдолтой сургалт боллоо.

ТАЙЛАН ГАРГАСАН:

НИСЛЭГИЙН ЦАГ УУРЫН ТӨВ
МЭДЭЭЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР



Б.СҮХБААТАР